



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сэлэнгэ аймаг

2022 он

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Ахлах аудитор: С.Баасансүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: [Baasansurens@audit.gov.mn](mailto:Baasansurens@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БИНХ	Багийн иргэдийн Нийтийн Хурал
БСГ	Боловсрол соёлын газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
ИХ	Иргэдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨГ	Орон нутгийн Өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон улсын Стандарт
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Н.ОТГОНЦОГТ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	726,700.8	852,158.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	219,975.1	227,088.6
33	АВЛАГА	198,110.5	281,321.6
35	БАРАА МАТЕРИАЛ	308,615.2	343,748.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,970,756.9	6,430,987.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,970,756.9	6,430,987.3
39200	Биет хөрөнгө	5,486,059.1	5,940,334.4
39300	Биет бус хөрөнгө	484,697.8	490,652.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,697,457.8	7,283,146.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,044.5	143,744.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,044.5	143,744.4
41300	Өглөг	4,044.5	143,744.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,693,413.2	7,139,401.6
51	Засгийн газрын хувь оролцоо	6,693,413.2	7,139,401.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,388,566.7	3,388,566.7
51200	Хуримтлагдсан үр дүн	749,447.7	770,857.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,555,398.8	2,979,977.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,697,457.8	7,283,146.0

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,572,270.10	4,349,551.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	204,071.40	244,804.80
110	Орлогын албан татвар	87,495.20	98,349.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	87,495.20	98,349.60
113	Хөрөнгийн албан татвар	750	32,176.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	115,826.20	114,278.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,060,448.60	497,800.60
120	Нийтлэг татварын бус орлого	1,060,448.60	487,800.60
122	Тусламжийн орлого	0	10,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,307,750.10	3,606,946.10
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,743,870.60	4,188,301.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,743,870.60	4,188,301.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,635,757.30	3,993,164.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,324,950.70	2,436,413.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	293,145.00	313,773.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	282,142.00	300,748.40
2104	Хангамж, бараа материалын зардал	93,441.30	97,190.60
2105	Нормативт зардал	158,490.20	241,063.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,970.20	54,278.10
2107	Томилолт, зочны зардал	4,177.00	1,271.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,142.00	35,501.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	378,299.00	512,923.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,108,113.20	195,136.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	828,399.60	161,250.30
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	785,853.20	139,840.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	42,546.40	21,410.00

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,706,086.70	4,150,207.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	204,071.40	244,804.80
110	Орлогын албан татвар	87,495.20	98,349.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	87,495.20	98,349.60
113	Хөрөнгийн албан татвар	750.00	32,176.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	115,826.20	114,278.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,518.50	22,973.90
1181	Газрын төлбөр	60,908.70	-
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	42,399.00	91,304.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	178,267.60	282,466.00
120	Нийтлэг татварын бус орлого	178,267.60	272,466.00
122	Тусламжийн орлого	-	10,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,323,747.70	3,622,936.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,418,140.50	3,797,513.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,418,140.50	3,797,513.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,293,825.80	3,602,316.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,325,568.60	2,434,459.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	296,387.00	315,736.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	287,195.30	296,848.60
2104	Хангамж, бараа материалын зардал	71,122.70	73,421.10
2105	Нормативт зардал	132,710.70	259,334.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,888.90	45,013.20
2107	Томилот, зочны зардал	4,177.00	1,271.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,252.50	38,506.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,523.10	137,725.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,124,314.70	195,196.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	287,946.20	352,694.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	107,620.10	185,581.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	107,620.10	185,581.00
2200	Дотоод эх үүсвэрээр	107,620.10	185,581.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(107,620.10)	(185,581.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(160,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	160,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	180,326.00	7,113.40
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,649.10	219,975.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	219,975.10	227,088.60

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
		Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,650,866.90	0	6,650,866.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,650,866.90	0	6,650,866.90
9	Тайлант үеийн үр дүн	42,546.40	0	42,546.40
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,693,413.20	0	6,693,413.20
11	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	6,693,413.20	0	6,693,413.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,693,413.20	0	6,693,413.20
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	66,839.60	0	66,839.60
19	Тайлант үеийн үр дүн	21,410.00	0	21,410.00
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,139,401.60	0	7,139,401.60

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,813,979.50</b>	<b>3,610,642.44</b>	<b>203,337.06</b>	<b>94.67</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,481,540.70</b>	<b>3,347,959.58</b>	<b>133,581.12</b>	<b>96.16</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,415,010.60</b>	<b>3,281,543.88</b>	<b>133,466.72</b>	<b>96.09</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,415,903.00</b>	<b>2,348,879.32</b>	<b>67,023.68</b>	<b>97.23</b>
210101	Үндсэн цалин	1,660,517.20	1,631,064.74	29,452.46	98.23
210102	Нэмэгдэл	572,886.40	534,182.52	38,703.88	93.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,786.00	5,153.79	1,632.21	75.95
210104	Урамшуулал	152,923.90	159,873.36	(6,949.46)	104.54
210105	Гэрээт ажлын хөлс	22,789.50	18,604.92	4,184.58	81.64
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>322,580.90</b>	<b>307,247.72</b>	<b>15,333.18</b>	<b>95.25</b>
210201	Тэтгэврийн даатгал	225,042.80	215,123.43	9,919.37	95.59
210202	Тэтгэмжийн даатгал	24,398.40	23,784.58	613.82	97.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,526.90	18,813.90	713.00	96.35
210204	Ажилгүйдлийн даатгал	4,866.60	4,505.36	361.24	92.58
210205	Эрүүл мэндийн даатгал	48,746.20	45,020.45	3,725.75	92.36
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>316,154.00</b>	<b>295,708.58</b>	<b>20,445.42</b>	<b>93.53</b>
210301	Гэрэл, цахилгаан	73,079.90	62,354.45	10,725.45	85.32
210302	Түлш, халаалт	208,172.00	195,466.83	12,705.17	93.90
210303	Цэвэр, бохир ус	34,902.10	37,887.30	(2,985.20)	108.55

**Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>63,729.70</b>	<b>62,295.84</b>	<b>1,433.86</b>	<b>97.75</b>
210401	Бичиг хэрэг	8,512.20	8,512.80	(0.60)	100.01
210402	Тээвэр, шатахуун	34,156.70	33,821.52	335.18	99.02
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,382.40	8,343.22	1,039.18	88.92
210404	Ном, хэвлэл	1,050.90	973.00	77.90	92.59
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,541.50	4,560.60	(19.10)	100.42
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,086.00	6,084.70	1.30	99.98
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>142,789.60</b>	<b>118,914.60</b>	<b>23,875.00</b>	<b>83.28</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,779.10	32,778.90	0.20	100.00
210502	Хоол, хүнс	93,529.00	69,656.60	23,872.40	74.48
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,481.50	16,479.10	2.40	99.99
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>88,861.00</b>	<b>88,829.50</b>	<b>31.50</b>	<b>99.96</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	46,438.90	46,438.90	0.00	100.00
210602	Тавилга	11,200.00	11,199.80	0.20	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,220.60	1,190.20	30.40	97.51
210604	Урсгал засвар	30,001.50	30,000.60	0.90	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,320.60</b>	<b>978.80</b>	<b>341.80</b>	<b>74.12</b>
210702	Дотоод албан томилолт	1,320.60	978.80	341.80	74.12
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>27,186.20</b>	<b>23,529.25</b>	<b>3,656.95</b>	<b>86.55</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,742.60	19,413.10	2,329.50	89.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,408.90	3,096.00	1,312.90	70.22
210803	Даатгалын үйлчилгээ	348.90	348.90	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	577.50	562.95	14.55	97.48
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	108.30	108.30	0.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>36,485.60</b>	<b>35,160.28</b>	<b>1,325.32</b>	<b>96.37</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,196.80	24,871.60	1,325.20	94.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,288.80	10,288.68	0.12	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>66,530.10</b>	<b>66,415.70</b>	<b>114.40</b>	<b>99.83</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>66,530.10</b>	<b>66,415.70</b>	<b>114.40</b>	<b>99.83</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,313.20	6,313.20	0.00	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,583.20	40,583.20	0.00	100.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	136.10	136.10	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,368.50	10,368.50	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,129.10	9,014.70	114.40	98.75
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>172,438.80</b>	<b>102,682.85</b>	<b>69,755.95</b>	<b>59.55</b>
220001	Барилга байгууламж	162,438.80	98,826.65	63,612.15	60.84
221001	Их засвар	10,000.00	3,856.20	6,143.80	38.56

**Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>160,000.00</b>	<b>160,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	160,000.00	160,000.00	0.00	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,813,979.50</b>	<b>3,572,717.75</b>	<b>241,261.75</b>	<b>93.67</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,570,398.30</b>	<b>2,476,236.40</b>	<b>94,161.90</b>	<b>96.34</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,570,398.30	2,76,236.40	94,161.90	96.34
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>970,224.00</b>	<b>940,995.36</b>	<b>29,228.64</b>	<b>96.99</b>
320001	Орон нутгийн төсвөөс	852,183.70	822,955.06	29,228.64	96.57
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	118,040.30	118,040.30	0.00	100.00
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>51,458.70</b>	<b>44,835.12</b>	<b>6,623.58</b>	<b>87.13</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	51,458.70	44,835.12	6,623.58	87.13
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>211,898.50</b>	<b>100,650.86</b>	<b>111,247.64</b>	<b>47.50</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	167,500.00	100,650.86	66,849.14	60.09
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	44,398.50	0	44,398.50	
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>10,000.00</b>	<b>10,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	10,000.00	10,000.00	0.00	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	128,757.12	(128,757.12)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	90,832.43	(90,832.43)	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	8	8	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>194</b>	<b>193</b>	<b>1.00</b>	<b>99.48</b>
620001	Удирдах ажилтан	17	17	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	100	99	1.00	99.00
620003	Үйлчлэх ажилтан	65	65	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	12	12	0.00	100.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>1,130.00</b>	<b>1,110.00</b>	<b>20.00</b>	<b>98.23</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>821</b>	<b>801</b>	<b>20.00</b>	<b>97.56</b>
630001	Төрийн өмчит ЕБС	821	801	20.00	97.56
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>309</b>	<b>309</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	309	309	0.00	100.00
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО</b>	<b>356</b>	<b>356</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	356	356	0.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>194</b>	<b>193</b>	<b>1.00</b>	<b>99.48</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11	0.00	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	111	111	0.00	100.00

**Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	7	6	1.00	85.71
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	27	27	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	32	32	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6	0.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>426,825.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>420,390.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>381,237.77</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>85,580.39</b>
210101	Үндсэн цалин	1,173.00
210102	Нэмэгдэл	84,337.39
210104	Урамшуулал	70.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,488.97</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,938.82
210202	Тэтгэмжийн даатгал	286.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	477.67
210204	Ажилгүйдлийн даатгал	511.29
210205	Эрүүл мэндийн даатгал	1,275.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,140.00</b>
210303	Цэвэр, бохир ус	1,140.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,063.53</b>
210401	Бичиг хэрэг	657.80
210402	Тээвэр, шатахуун	9,799.23
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	110.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	714.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	782.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>140,419.46</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	128,581.46
210502	Хоол, хүнс	11,838.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>27,490.79</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,190.29
210604	Урсгал засвар	2,300.50
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>292.80</b>
210702	Дотоод албан томилолт	292.80
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,546.56</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,546.56
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>88,215.27</b>

**Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,645.27
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	570.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,152.24</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,600.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,600.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,552.24</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	19.20
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,533.04
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,435.22</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,435.22</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,435.22
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>426,825.23</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>426,825.23</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,450.00
131103	ЗГНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,018.68
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	102,513.45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,131.60
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	268,711.51

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн / цаашид Алтанбулаг сумын ТТЗ гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөх, жолоочийн тооцооны хуудаст холбогдох үзүүлэлтүүдийг бүрэн гүйцэт бүртгэх, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулах, албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдэл олгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын ТТЗ нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/106 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтанбулаг сумын ТТЗ нь “Төрийн үйлчилгээг иргэнд шуурхай хүргэж, сумынхаа хөгжил дэвшлийг шинэ шатанд хүргэхийн төлөө хамтдаа бүтээцгээе.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Алтанбулаг сумын ТТЗ нь тайлант онд дараах үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны

журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,

- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус сумын төсөвт байгууллагуудын мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын Засаг даргын баталсан “Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу сумын Санхүүгийн албанаас харьяа төр, төсвийн байгууллагуудад төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 1-3 удаа /Сумын 1,2,3 дугаар цэцэрлэгүүдэд 2, ЕБС-д 3, Соёлын төвд 1 удаа/ -гийн дотоод хяналт, шалгалт хийж, санхүү, нягтлан бодох бүртгэл, шилэн дансны мэдээлэлд зөвлөмж өгч, гарсан алдаа, зөрчлийн талаар төсвийн шууд захирагч нарт танилцуулан, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 4,186,210.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 62,793.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 47,094.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 114,920.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 445,143.4 мянган төгрөг болж, 330,223.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	219,975.1	227,088.6	7,113.5	74.2
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>219,975.1</b>	<b>227,088.6</b>	<b>7,113.5</b>	<b>74.2</b>

*Эх сурвалж: Алтанбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 136,256.1 мянган төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 69,756.1 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 21,076.4 мянган төгрөг СХС-ийн дансанд тус тус байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 198,110.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 281,321.5 мянган төгрөг болж, 83,211.0 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	79.7	79.7
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	3,821.1	8,172.3	4,351.2

**Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Бусад авлага	7.0	7,799.6	7,792.6
Зээлийн авлага	194,282.4	265,269.9	70,987.5
<b>Дүн</b>	<b>198,110.5</b>	<b>281,321.5</b>	<b>83,211.0</b>

*Эх сурвалж: Алтанбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд СХС-аас 160,000.0 мянган төгрөгийн зээл нэмж олгосноос голлон шалтгаалсан байна.

Бусад авлага дансны үлдэгдэлд ЭМТ-ийн ЭМДС-аас авах санхүүжилтийн 7,799.6 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Авлагын эцсийн үлдэгдлийн 95.6 хувь буюу 273,442.2 мянган төгрөгийг СХС-ийн зээл, хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд 2013-2017 онуудад олгосон эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 62,800.0 мянган төгрөгийн зээлийн, 1,235.1 мянган төгрөгийн зээлийн хүүгийн авлагууд бүртгэлтэй байна.

Насжилт өндөртэй /3-аас дээш жил/ СХС-ийн дээрх авлагыг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж, нэхэмжлэлийг хүргүүлснээр зээлийн үлдэгдлийг 2022 онд барагдуулж дуусгахаар 4 иргэнтэй эвлэрлийн гэрээ байгуулж, 1 иргэнийг Цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулах ажиллагаа хийлгэж байна.

### **3.5.3 Бараа материал**

Бараа материалын эхний үлдэгдэл 308,615.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 343,748.6 мянган төгрөг болж, 35,133.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>Өсөлт (+), Бууралт (-)</b>
Тусгай зориулалтын материал	-	478.0	478.0
Эм боох материал	19,014.4	26,478.2	7,463.8
Бичиг хэргийн материал	12,845.3	15,596.2	2,750.9
Аж ахуйн материал	231,647.5	239,280.4	7,632.9
Түлш, шатах тослох материал	3,052.0	2,552.6	(499.4)
Барилгын засварын материал	569.0	261.0	(308.0)
Хүнсний материал	1,035.9	6,751.8	5,715.9
Бусад хангамжийн материал	40,451.1	52,350.4	11,899.3
<b>Дүн</b>	<b>308,615.2</b>	<b>343,748.6</b>	<b>35,133.4</b>

*Эх сурвалж: Алтанбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 35,133.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 478,158.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, хандив тусламжаар 36,888.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, данснаас дансанд 1,872.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан зэргээр нийт 516,919.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 411,797.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 50,998.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн, 18,990.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

### **Аудитын илрүүлэлт:**

СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ

1. Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгдээгүй байна. Үүнд:

- ИТХ нь 1,662.0 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 19,202.9 мянган төгрөгийн,
- ЭМТ нь 20,561.0 мянган төгрөгийн,
- Соёлын төв нь 340.9 мянган төгрөгийн,
- ЕБС нь 74,215.8 мянган төгрөгийн,
- 1 дүгээр цэцэрлэг нь 11,395.4 мянган төгрөгийн,
- 2 дугаар цэцэрлэг нь 11,873.2 мянган төгрөгийн,
- 3 дугаар цэцэрлэг нь 4,147.0 мянган төгрөгийн гэх мэт.

2. ЕБС, 1,2,3 дугаар цэцэрлэгийн хүнсний материалын худалдан авалтыг 11-20 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн дээр түүвэрлэж үзэхэд гэрээнд санал болгосон үнийн дүнгээс 8-10 хувиар нэмэгдүүлэн худалдан авалт хийсэн байна.

3. ИТХ нь бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, зарлагын баримтгүйгээр ГХУС зардлаас сургалтын материалын үнэнд 350.0 мянган төгрөгийг Гоулд булаг ХХК-д шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан байна.

4. ИТХ, ЗДТГ-ын жолоочийн тооцооны хуудаст спидометрийн заалт бичигдээгүй байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл /анхны өртгөөр/ 8,240,384.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 8,085,635.2 мянган төгрөг болж 154,749.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	4,037,493.6	4,100,367.9	62,874.3
Хуримтлагдсан элэгдэл	(211,233.5)	(309,968.1)	(98,734.6)
Авто-тээврийн хэрэгсэл	269,786.2	302,486.2	32,700.0
Хуримтлагдсан элэгдэл	(216,095.1)	(223,687.9)	(7,592.8)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	670,689.2	732,014.1	61,324.9
Хуримтлагдсан элэгдэл	(421,151.2)	(288,926.9)	132,224.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	313,542.0	227,786.6	(85,755.4)
Хуримтлагдсан элэгдэл	(199,805.9)	(85,078.5)	114,727.4
Зам, гүүрийн байгууламж	2,316,162.9	2,067,807.2	(248,355.7)
Хуримтлагдсан элэгдэл	(1,186,904.3)	(708,392.7)	478,511.6
Бусад үндсэн хөрөнгө	126,659.6	138,847.0	12,187.4
Хуримтлагдсан элэгдэл	(30,129.5)	(33,310.6)	(3,181.1)
Ном	17,045.1	20,389.9	3,344.8
Программ хангамж	8,267.9	15,198.2	6,930.3
Хуримтлагдсан элэгдэл	(4,308.3)	(5,283.3)	(975.0)
Бусад биет бус хөрөнгө	480,738.2	480,738.2	-
<b>Дүн</b>	<b>5,970,756.9</b>	<b>6,430,987.3</b>	<b>460,230.4</b>

Эх сурвалж: Алтанбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 154,749.5 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж, дахин үнэлснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 82,898.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив тусламжаар 235,767.1 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр 157,347.7 мянган төгрөг, дахин үнэлгээгээр 427,714.4 мянган төгрөг зэрэг нийт 903,727.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол элэгдлээрээ өртгөө нөхсөн 893,182.9 мянган төгрөгийн анхны үнэтэй хөрөнгийг данс бүртгэлээс хассан, 165,293.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, устгасан зэрэг нийт 1,058,476.8 мянган төгрөгөөр хасагдсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4,044.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 143,744.4 мянган төгрөг болж, 139,699.9 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой өглөг	-	-	-	
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-	
Татаас, санхүүжилтийн өглөг	3,312.2	-	(3,312.2)	
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдон гарсан өглөг	-	130,000.0	130,000.0	100
Байгууллагад төлөх өглөг	732.3	13,744.4	13,012.1	94.6
<b>Нийт дүн</b>	<b>4,044.5</b>	<b>143,744.4</b>	<b>139,699.9</b>	<b>97.1</b>

*Эх сурвалж: Алтанбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд ЗДТГ нь сумын халаалтын төвийн барилгыг гэрээний дагуу шилжүүлэн авч, тус халаалтын төвийг эзэмшиж байсан Алтанбилэг компанийн 2 ширхэг халаалтын тогоо, дагалдах тоног төхөөрөмжийн үнийг төлөхөөр гэрээ байгуулж, 130,000.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлагнаснаас голлон шалтгаалсан байна.

Байгууллагад төлөх өр төлбөрийн дансны үлдэгдэлд ЭМДС-гийн санхүүжилтийн дутуугаас сумын ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн 1,362.0 мянган төгрөг, үнэ тарифын зөрүү, санхүүжилтийн Соёлын төвийн халаалтын зардлын 3,400.4 мянган төгрөг, ОНХО-ын 732.4 мянган төгрөг /2000 онд мал бүхий иргэдэд өвс бэлдүүлсний ажлын хөлсний өр төлбөр/, ЕБС-ийн хоолны зардлын 450.0 мянган төгрөг зэрэг нийт 13,744.4 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас ЭМТ нь 1,362.0 мянган төгрөгийн эмийн, ЕБС нь материалын төлбөрийн 450.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- ЕБС нь өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр НДШ-ийн шимтгэлийн өглөг гэж тайлант оны батлагдсан төсвөөс 271.9 мянган төгрөгийг төлсөн байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 12,659,541.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 14,270,831.3 мянган төгрөг болж, 1,611,289.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,388,566.7	3,388,566.7	-	-
Өмнөх үеийн үр дүн	706,901.3	749,447.7	42,546.4	5.6
Тайлант үеийн үр дүн	42,546.4	21,409.9	(21,136.5)	98.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,555,398.8	2,979,977.2	424,578.4	14.2
<b>Дүн</b>	<b>6,693,413.2</b>	<b>7,139,401.5</b>	<b>445,988.3</b>	<b>6.2</b>

*Эх сурвалж: Алтанбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 445,988.3 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүгээс шалтгаалсан байна.

### 3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон сумын ЗДТГ-ын журмын хашааны төлбөрийн 1,961.0 мянган төгрөг, Соёлын төвийн хөгжмийн зэмсгийн түрээс, дугуйлангийн төлбөрийн 955.5 мянган төгрөг зэрэг нийт 2,916.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- ЭМТ нь кассын орлогыг орлого орсон тухай бүр нэмэлт санхүүжилтийн дансанд тушаалгүйгээр өөрөөр хэлбэл ковид-19 өвчнийг илрүүлэх түргэвчилсэн оношлуурын төлбөрийн 14,342.5 мянган төгрөгийн орлогыг 31 удаа, эмийн сангийн эмийн борлуулалтын 22,235.3 мянган төгрөгийн орлогыг 89 удаа бөөн дүнгээр тушаасан байна.

### 3.5.8 Зардлын данс

Тайлант онд зардлын данстай холбоотой 33,770.2 мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

##### **ТТЗ :**

- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн “2 дугаар багт хүүхдийн тоглоомын талбай хийх” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч Хярааны хонхор ХХК-д 513.7 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон,

- ЗДНХ-өөс урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжтой “Алтанбулаг сумын 2021-2025 онд хэрэгжүүлэх ойн сангийн менежментийн төлөвлөгөө боловсруулах”-д 5,000.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- Засаг даргын захирамж, ЗДЗ-ийн хурлын тэмдэглэл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ЗДНХ-өөс сумын танилцуулга 100 ширхгийг хийлгэхэд 350.0 мянган төгрөг, цагаан сарын баяраар ахмадуудад мэндчилгээ, гарын бэлэг авахад 200.0 мянган төгрөг зэрэг нийт 550.0 мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

#### **ЗДТГ:**

- Жижүүрээр ажиллаж байсан Н.Халхголын нөхөн тооцуулж, баталгаажуулаагүй нэг жилийн хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулж тогтоосны улмаас өндөр насны тэтгэвэр гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тэтгэмжид 813,3 төгрөгийг илүү олгосон,
- Мэргэжилтэн Б.Мөнхзулд “Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан”, ХАА-н тасгийн дарга Б.Буян-Өлзийд “Статистик, бүртгэлийн тэргүүний ажилтан ажилтан” цол тэмдгээр шагнагдсанд тус бүр 100.0 мянган төгрөгийн шагнал олгосон,
- Сумын Засаг даргын 2021 оны Б/20 дугаар захирамжаар ЗДТГ-ын албан хаагчдад ковид 19 цар тахлын үед илүү цагаар ажилласан хөлсийг “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулаагүй, тухай бүр бус жилийн эцсийн цалингийн хэмнэлтээс буюу 12 дугаар сард нийт 13,243.3 мянган төгрөгийг олгосон,

#### **ЭМТ:**

- Ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 15-25 хувиар тооцож, нийт 9,495.6 мянган төгрөг олгосон байна.

#### **Соёлын төв:**

- Бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, бэлэн мөнгө тушаасан кассын орлогын баримтгүйгээр уран бүтээлийн зардлаас бүжгийн багш Н.Оюунтуяагийн сургалтын төлбөрт 150.0 мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

#### **ЕБС:**

- Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр Н.Нарантуяа, Т.Тулга, Ж.Сэлэнгэ нарт 258.1 мянган төгрөгийн анги даалт, кабинетын нэмэгдэл олгосон,
- Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас ажилласан цагийн хөлсийг буруу тооцож гурван багшид 331.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон,
- Дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэргүй буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр захирал Б.Эрдэнэ-Очирт 197.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон,
- “Боловсролын тэргүүний ажилтан” тэмдгээр шагнагдсан багш Ц.Одгэрэлд 100.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон,

#### **1 дүгээр Цэцэрлэг:**

- Багш, ажилтнуудад сумын Засаг даргын А/01, А/17, А/21 дугаар захирамжаар тогтоосон цагаас илүү тооцон 413.4 мянган төгрөгийг олгосон.

## 2 дугаар цэцэрлэг:

- Сумын Засаг даргын 2021 оны А/01, А/17, А/21 дугаар захирамжаар багш ажилтнуудын илүү цагийн хөлсийг тушаалд заасан цагаас илүү тооцон 744.1 мянган төгрөгийн цалин олгосон,
- Сахилгын шийтгэл ногдуулсан жижүүр Б.Болдод сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад 706.6 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.

## 3 дугаар цэцэрлэг:

- Сумын Засаг даргын 2021 оны А/01, А/17, А/21 дүгээр захирамжаар багш ажилтнуудад илүү цагийн хөлс олгохдоо тушаалд заасан цагаас 513.4 мянган төгрөгийг илүү олгосон.

## 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Алтанбулаг сумын ИТХ-ын “2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 2021 оны 29 дүгээр тогтоолоор тайлант онд татварын орлого 228,983.0 мянган төгрөг, татварын бус орлого 87,642.5 мянган төгрөг зэрэг нийт 316,625.5 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 418,705.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 32.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
Хувь хүний орлогын албан татвар	139,699.9	41,601.8	(98,098.1)	60.7
Бууны албан татвар	1,500.0	2,693.1	1,193.1	179.5
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	16,000.0	17,983.2	1,983.2	112.4
Улсын тэмдэгтийн хураамж	9,000.0	5,697.9	(3,302.3)	63.3
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	2,468.0	635.0	(1,833.0)	25.7
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	27,799.8	90,669.5	62,869.7	326.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	6,000.0	450.0	(5,550.0)	7.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	20,315.3	16,826.1	(3,489.2)	82.8
Хөрөнгийн орлого-Банкны хүүгийн орлого	6,200.0	38,764.5	32,564.5	625.2
Малын тоо толгойн албан татвар	-	29,483.7	29,483.7	-
Хүү, торгуулийн орлого	65,142.5	129,907.8	64,765.3	199.4
Бусад орлого	20,000.0	41,907.3	21,907.3	209.5

**Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,500.0	2,086.0	(414.0)	83.4
<b>Нийт дүн</b>	<b>316,625.5</b>	<b>418,705.9</b>	<b>102,080.4</b>	<b>132.2</b>

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 62,869.7 мянган төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн орлого 32,564.5 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 29,483.7 мянган төгрөгөөр, хүү, торгуулийн орлого 64,765.3 мянган төгрөг, бусад орлого 21,907.3 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол хувь хүний орлогын албан татвар 98,098.1 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 3,302.3 мянган төгрөгөөр, ан агнуурын нөөц ашигласны төлбөр 1,833.0 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 5,550.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

**Давж биелсэн орлогууд:**

- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 62,869.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь Засгийн газрын тогтоолоор гоожингийн м<sup>3</sup>-ийн үнэ 2.5-3.2 дахин үнэ өссөнтэй холбоотой,
- Хадгаламжийн хүүгийн орлого 32,564.5 мянган төгрөгөөр давсан нь банкны хадгаламж эзэмшигчдийн орлогыг бага төлөвлөсөнтэй холбоотой,
- Малын тоо толгойн албан татварын хууль шинээр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой 29,483.7 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй орлого төвлөрүүлсэн,
- Хүү, торгуулийн орлого 64,765.3 мянган төгрөгөөр давсан нь ойн нөхөрлөлүүд гэрээний үүргээ биелүүлээгүйгээс торгууль ногдуулсантай холбоотой,
- Нэр заагдаагүй бусад орлого 21,907.3 мянган төгрөгөөр давсан нь шүүхийн шийдвэрээр хураагдсан хөрөнгийг борлуулсан болон тамхины тусгай зөвшөөрлийн хураамж нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Тасарсан орлогууд:**

- Хувь хүний орлогын албан татвар 98,098.1 мянган төгрөгөөр тасарсан нь ковид-19 цар тахлын улмаас Алтанбулаг боомтын үйл ажиллагааг зогсоосноос шалтгаалсан,
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 3,302.3 мянган төгрөг */Сүүлийн 3 жил дараалан тасарсан/* -өөр тасарсан нь орлогын төлөвлөгөөг бодит байдлаас өндөр баталсантай холбоотой,
- Ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого 1,833.0 мянган төгрөгөөр тасарсан нь ковид-19 болон малын шүлхий өвчний улмаас иргэдийн зорчих хөдөлгөөн хязгаарлагдаж, ан агнуурын зөвшөөрөл олгоогүйтэй холбоотой,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 5,550.0 мянган төгрөгөөр тасарсан нь ковид-19 цар тахлын улмаас зам, барилгын компаниудын үйл ажиллагаа хязгаарлагдсантай холбоотой,

**Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 3,498,645.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өргөн барьсан төсвийн төслийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор нийт зарлагыг 3,498,645.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагыг 85,000.0 мянган төгрөгөөр тусад нь баталсан байна.

Ковид 19 цар тахлын халдварын тархалтыг зогсоох ажиллагаанд төсвийн зохицуулалт хийх, дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан сумын ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор орлогын төлөвлөгөөг 131,856.4 мянган төгрөгөөр нэмж тодотгон, сумын төсвийг **3,630,501.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Төсвийн тодотголоор дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ОНЕО-ын урьд оны үлдэгдэл 75,220.4 мянган төгрөгийг нэмж тодотгосон,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдэл 44,398.5 мянган төгрөг, Гачуурт ХХК-иас өгсөн хандив 10,000.0 мянган төгрөгийг тус тус нэмж тодотгосон,
- Сумын татварын орлогын төлөвлөгөөг 63,062.7 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон,
- Сумын ИТХТ-ийн даргаар ажиллаж байсан Н.Ариунжаргалын сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөний нэг удаагийн тэтгэмж 6,313.2 мянган төгрөг, ИХ-ын төлөөлөгчдийн 3,4 дүгээр улирлын урамшуулал 2,240.0 мянган төгрөг, БИНХ-ын дарга, тэргүүлэгчдийн цалин, урамшил 1,604.5 мянган төгрөг зэрэг нийт 10,157.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон,
- Аймгаас суманд өгөх санхүүгийн дэмжлэгээс ЭМТ-ийн халаалтын зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн 30 дугаар тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагыг 165,000.0 мянган төгрөгөөр тусад нь баталсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт нийт 3,795,501.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас аймгийн Засаг даргын 2021 оны А/372 дугаар захирамжаар ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийгдэж тус сумын ТЗШ-ийн байгууллагуудын төсвийг нийт 18,478.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалж төсвийн төлөвлөгөө **3,813,979.5** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны нийт төсвөөс 3,481,540.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 172,438.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 160,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 462,837.8 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 389,345.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 51,458.7 мянган төгрөгийг ЭМДС-аас, 172,438.8 мянган төгрөгийг ОНХС-аас, 2,570,398.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 2,500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос, 80,641.5 мянган төгрөгийг СХС-аас олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, 84,358.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 462,837.8 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, тусгай зориулалтын шилжүүлгээс 2,594,560.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 418,705.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 44,835.1 мянган төгрөг, СХС-ийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс 165,000.0 мянган төгрөг, ОНХС-аас 118,040.3 мянган төгрөг, аж ахуйн нэгжийн хандив, тусламжаас 10,000.0 мянган төгрөг зэрэг нийт **3,813,979.5** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,610,642.4 мянган төгрөг буюу 94.6 хувьтай тайлагнагдсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшил 67,023.6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 15,333.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 20,445.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 1,433.8 мянган төгрөгөөр, нормативт зардал 23,875.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 31.5 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 341.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 3,941.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 3,656.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1,325.3 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 114.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 69,756.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нийт 8 /урьд оноос шилжих хөрөнгө оруулалт 2, шинээр эхлэх 6/ төсөл, арга хэмжээнд 172,438.8 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 102,682.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 69,756.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчдаас 102,513.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 46,131.6 мянган төгрөг, ЭМДС-ийн нэмэлт орлого 268,711.5 мянган төгрөг, хандив

тусламжийн орлого 8,450.0 мянган төгрөг, ЗДНХ-өөс жилийн эцсийн мал тооллогын шатахууны зардалд хуваарилсан 1,018.6 мянган төгрөг зэрэг нийт **426,825.2** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

**Дээд шатны төсвийн захирагчдаас:**

- Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Хамтарсан баг”-ийн зардалд 300.0 мянган төгрөг,
- Аймгийн ОНХО, замын сангийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт 43,024.0 мянган төгрөг,
- ХХААГ-аас ургац хураалтын мэдээ, малын үзлэг ангилалт болон махны өргөтгөсөн худалдааны зардалд 856.3 мянган төгрөг,
- Статистикийн хэлтсээс аж ахуйн нэгж, байгууллагын болон мал тооллогын зардалд 787.2 мянган төгрөг,
- ТӨБЗГ-аас цахим тендерийн хураамж 315.0 мянган төгрөг,
- БСШУЯ-аас ерөнхий боловсролын сургуульд “Бага ангийн сурагчдын хоцрогдол арилгах” төслийн санхүүжилт 7,590.1 мянган төгрөг,
- БСГ-аас ерөнхий боловсролын сургуульд шалгалтын бичиг хэргийн зардалд 420.0 мянган төгрөг, түрээсийн сурах бичгийн үнэ 4,625.4 мянган төгрөг, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал ЕБС-д 381.0 мянган төгрөг, 1,2,3 дугаар цэцэрлэгт 333.0 мянган төгрөг,
- ЭМГ-аас ковидын тасагт ажилласан албан хаагчдын цалин, илүү цагийн хөлсний зардалд 42,170.2 мянган төгрөг, ЭМДС-аас ковидын тасагт хэвтэн эмчлүүлэгчийн, гэрийн эргэлтийн, вакцин дархлаажуулалтын, албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардалд 268,711.5 мянган төгрөг,
- Сумын Онцгой комиссоос ковид 19 цар тахлын үед гал тогоонд ажилласан ажиллагсдын илүү цагийн хөлсөнд ЕБС-д 1,277.9 мянган төгрөг, 1,2,3 дугаар цэцэрлэгт 3,209.6 мянган төгрөг,
- Сумын ЗДНХ-өөс ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засварт 1,164.0 мянган төгрөг зэргийг тус тус шилжүүлсэн байна.

**Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:**

- ЗДТГ нь хандивын орлого 8,450.0 мянган төгрөг,
- ЭМТ нь эмийн сангийн эмийн борлуулалтын орлого 22,235.3 мянган төгрөг, ковид 19-ын түргэвчилсэн оношлуурын шинжилгээний орлого 16,442.0 мянган төгрөг, PCR шинжилгээний орлого 2,525.0 мянган төгрөг зэрэг нийт 41,202.3 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс, НДШ-ийн зардалд 94,069.4 мянган төгрөг, байр ашиглалтын зардалд 1,140.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 12,063.5 мянган төгрөг, нормативт зардалд 140,419.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 27,490.8 мянган төгрөг, томилолтын зардалд 292.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 17,546.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 88,215.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалд 34,600.0 мянган төгрөг, хөрөнгийн

зардалд 6,435.2 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 4,552.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй атал Алтанбилэг ХХК-ийн хүсэлт, аймгийн ОНӨГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 455 дугаар албан бичгийг үндэслэн сумын халаалтын төвийн уурын зуухны 2 ширхэг тогоо, дагалдах тоног төхөөрөмжийг 130,000.0 мянган төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулж, сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд өр төлбөрөөр тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Хүснэгт: 8 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл*

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Засаг дарга	121	121	-	-
2	ИТХ	151	151	-	-
3	ЗДТГ	151	148	3	-
4	ЭМТ	151	133	18	-
5	Соёлын төв	151	150	1	-
	<b>Нийт дүн</b>	<b>725</b>	<b>703</b>	<b>22</b>	<b>-</b>

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн түвшинд давхардсан тоогоор мэдээлбэл зохих 725 мэдээллээс 703 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 22 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

1.Алтанбулаг сумын ТТЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 3,813,979.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3,610,642.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.3 хувиар хэмнэсэн байна.

Харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- ИТХ-ын тайлант оны үйл ажиллагаанд 69,971.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 67,748.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.1 хувиар хэмнэсэн,
- ЗДТГ-ын тайлант оны үйл ажиллагаанд 408,660.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 400,252.2 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.0 хувиар хэмнэсэн,
- ЭМТ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 570,934.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 559,677.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.9 хувиар хэмнэсэн,
- Соёлын төвийн тайлант оны үйл ажиллагаанд 97,785.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 97,564.2 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.2 хувиар хэмнэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 2,227.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 96,815.7 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 83,963.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	2,227.4	1	2,227.4	-	-	100
Албан шаардлага	4	96,815.7	3	96,815.7	1	-	75
Зөвлөмж	2	83,963.1	2	83,963.1	-	-	100
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>183,006.2</b>	<b>6</b>	<b>183,006.2</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>85.7</b>

Өмнөх аудитаар өгсөн Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг хэрэгжүүлж, төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх түвшинтэй харьцуулан гаргаж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020

оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**3.11.1** Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, ашиг” болон “ОНХС-ийн 2021 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн” сэдэвт аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

## 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 8, орон нутгийн төсөл сангийн 2 нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1, 2, 3 дугаар цэцэрлэг, ЕБС-ийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 4 байгууллага, 2 төсөл сангийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Төсвийн төвлөрүүлсэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 294,887.9 мянган төгрөгийн 44 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 75,615.5 мянган төгрөгийн 12 алдааг залруулж, 4,796.1 мянган төгрөгийн 11 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 25,034.7 мянган төгрөгийн 8 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 189,441.6 мянган төгрөгийн 13 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Бие даасан дүгнэлт гарсан дээрх 4 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

**Төсвийн төвлөрүүлэн захирагчийн түвшний аудитаар нийт 135,695.0 мянган төгрөгийн 17 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 22,010.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 1,532.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 24,312.8 мянган төгрөгийн 6 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 87,840.2 мянган төгрөгийн 4 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.**

### 4.1 Залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **22,010.0** мянган төгрөгийн алдааг залруулж, санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаж, баталгаажууллаа. Үүнд:

#### **ЗДТГ:**

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын ЗДТГ нь 15,997.6 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагын тооцооны өмнөх оны устгах бичилтийг хийгээгүйгээс санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн авлага, өглөгийн эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнагдсаныг залруулав.
- Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн туслах үйл ажиллагааны орлогын 1,250.0 мянган төгрөгийг давхар бүртгэж, санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогыг илүү тайлагнасныг залруулга хийлгэв.

#### **Соёлын төв:**

- Түлш халаалтын зардлын 3,400.4 мянган төгрөгийн өр төлбөрийг бүртгэл, тайланд тусгаагүй байсныг тусгуулж, залруулав.

#### **ЭМТ:**

- Монгол эм импэкс компанийн Сэлэнгэ салбарт төлөх эмийн зардлын 1,362.0 мянган төгрөгийн өр төлбөрийг бүртгэл, тайланд тусгаагүй байсныг тусгуулж, залруулав.

#### **4.2 Төлбөрийн акт:**

1. ЗДТГ нь жижүүр Н.Халхголын нөхөн тооцуулж, баталгаажуулаагүй нэг жилийн хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулж тогтоосны улмаас өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тэтгэмжид 818.3 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан *“Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”* болон *“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”* 2020 оны 151 дүгээр тогтоолын 3.1.12 дахь *“Нийгмийн шилжилтийн явцад ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний 1990-1995 оны хооронд ажилласан жил тасарсан иргэнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас зохих журмын дагуу олгосон баталгаажуулалтын хуудсыг үндэслэн ажилласнаар нөхөн тооцуулсан хугацаа.”* гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Мэргэжилтэн Б.Мөнхзулд *“Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан”*, ХАА-н тасгийн дарга Б.Буян-Өлзийд *“Статистик, бүртгэлийн тэргүүний ажилтан ажилтан”* цол тэмдгээр шагнагдсанд тус бүр 100.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан *“Төрийн албан хаагчид шагнал олгох журам”*-ын 1.7

дахь “Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шагналыг дагалдуулан олгосон мөнгөн шагналыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3.Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн “2 дугаар багт хүүхдийн тоглоомын талбай хийх” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч Хярааны хонхор ХХК-д 513.7 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон нь сумын ЗДТГ-ын 2021 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр гүйцэтгэгчтэй байгуулсан СЭААБСЗДТГ/202105006 дугаартай гэрээний 2 дахь “Гэрээний нийт: 20,000,000 төгрөг. Үүнээс: Захиалагчийн хяналтын зардал 342456, Зураг төсвийн үнэ 171228, Магадалшгүй ажлын зардал 342456” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон санхүүжилтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

#### 4.3 Албан шаардлага:

1. ЗДНХ-өөс урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжтой “Алтанбулаг сумын 2021-2025 онд хэрэгжүүлэх ойн сангийн менежментийн төлөвлөгөө боловсруулах”-д 5,000.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь “Энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-өөс урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжтой арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Засаг даргын захирамж, ЗДЗ-ийн хурлын тэмдэглэл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ЗДНХ-өөс сумын танилцуулга 100 ширхгийг хийлгэхэд 350.0 мянган төгрөг, цагаан сарын баяраар ахмадуудад мэндчилгээ, гарын бэлэг авахад 200.0 мянган төгрөг зэрэг нийт 550.0 мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4.1 дэх “Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийг Засаг даргын захирамж, ЗДЗ-ийн хурлын тэмдэглэл зэрэг анхан шатны баримтыг үндэслэн зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг комиссын актаар хүлээн аваагүй байхад “2 дугаар багийн хүүхдийн тоглоомын талбай хийх /солдат/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч Хярааны хонхор ХХК-д 3,657.5 мянган төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 10.6 дахь “Захиалагч нь төсөл, арга хэмжээний эцсийн санхүүжилтийн хүсэлтийг ирүүлэхдээ барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.”, 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн СЭААБСЗДТГ/202105006 дугаар гэрээний “Тусгай нөхцөл”-ийн 47 дахь “... ажлыг бүрэн хүлээлгэн өгсний дараа сүүлийн үлдэгдэл санхүүжилт 20 хувийг олгоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хүлээн авсан комиссын актыг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг олгож байх албан шаардлага хүргүүлэх.

4. ЗДТГ-ын албан хаагчдад ковид-19 цар тахлын үед илүү цагаар ажилласан хөлсийг “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулаагүй, тухай бүр бус жилийн эцсийн цалингийн хэмнэлтээс буюу 12 дугаар сард 13,243.3 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3.1 дэх “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан **“Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу** илүү цагаар, ... ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ.” , 3.2 дахь “ **Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар... ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно.**” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн хөлсийг “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулсны үндсэн дээр тухай бүх буюу дараа сард нь олгож байх албан шаардлага хүргүүлэх.

5. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас ЭМТ нь эмийн зардлын 1,362.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог **хянах**, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн

заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

6. Бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, зарлагын баримтгүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ИТХ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас сургалтын материалын үнэнд 350.0 мянган төгрөгийг Гоулд булаг ХХК-д шилжүүлсэн, Соёлын төв нь уран бүтээлийн зардлаас бүжгийн багш Н.Оюунтуяагийн сургалтын төлбөрт 150.0 мянган төгрөгийг кассаас зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

#### **4.4 Зөвлөмж:**

##### **4.4.1 Мөнгөн кассын ажиллагааны журамтай холбоотой асуудал:**

1.1 Илрүүлэлт: ЭМТ нь кассын орлогыг орлого орсон тухай бүр нэмэлт санхүүжилтийн дансанд тушаалгүйгээр өөрөөр хэлбэл ковид 19 өвчнийг илрүүлэх түргэвчилсэн оношлуурын төлбөрийн 14,342.5 мянган төгрөгийн орлогыг 31 удаа, эмийн сангийн эмийн борлуулалтын 22,235.3 мянган төгрөгийн орлогыг 89 удаа бөөн дүнгээр тушаасан байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 дэх “*Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана.*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид тухай бүр өөрийн орлогыг харилцах дансанд тушааж, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах.

##### **4.4.2 Анхан шатны болон цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал:**

2.1 Илрүүлэлт: Сумын ИТХ, ЗДТГ нь жолоочийн тооцооны хуудаст холбогдох үзүүлэлтүүдийг / спидометрийн заалт / бүрэн бүртгэлгүйгээр шатахууны тооцоог хийсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын

хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг тус тус зөрчсөн тул цаашид жолоочийн тооцооны хуудаст холбогдох үзүүлэлтүүдийг бүрэн гүйцэт бүртгэх, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2.3 Илрүүлэлт: Тайлант онд ИТХ нь 1,662.0 мянган төгрөгийн, ЗДТГ нь 19,202.9 мянган төгрөгийн, ЭМТ нь 20,561.0 мянган төгрөгийн, Соёлын төв нь 340.9 мянган төгрөгийн зэрэг нийт **41,766.8** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.4 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан “загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх.

#### **4.4.3 Зардлын данстай холбоотой асуудал:**

3.1 Илрүүлэлт: ЭМТ нь ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 15-25 хувиар тооцож, нийт 9,495.6 мянган төгрөг олгосон байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3 дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан **шалгуур үзүүлэлтийн дагуу** албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалттай нийцэхгүй ба “Үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдлийг олгож байх.

#### **4.4.4 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:**

4.1 Илрүүлэлт: ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ЗДТГ нь 151 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- ЭМТ нь 151 мэдээлэл байршуулахаас 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Соёлын төв нь 151 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1- 6.4 дэх заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Запруулга		Төлбөрийн акт		Үүнээс				
				᠐	Дүн	᠐	Дүн	᠐	Дүн	Хариуцлага тооцуулах		Албан шаардлага		Зөвлөмж
										᠐	Дүн	᠐	Дүн	
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>														
1	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	Санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын ЗДТГ нь татаас санхүүжилтийн авлагын тооцооны өмнөх оны устгах бичилтийг хийгээгүй байсныг залруулав.	1	15,997.6	1	15,997.6							
2	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн туслах үйл ажиллагааны орлогын дүнг давхар бүртгэж, санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогыг илүү тайлагнасныг залруулав.	1	1,250.0	1	1,250.0							
3	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	Соёлын төв нь түлш халаалтын зардлын өр төлбөрийг бүртгэл, тайланд тусгаагүй байсныг тусгуулж, залруулав.	1	3,400.4	1	3,400.4							
4	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	ЭМТ нь эмийн өр төлбөрийг бүртгэл, тайланд тусгаагүй байсныг тусгуулж, залруулав.	1	1,362.0	1	1,362.0							
5	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	Сумын ЗДТГ нь өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг илүү олгосон.	1	818.3			1	818.3					

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	Сумын ЗДТГ нь "Тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнагдсан 2 ажилтанд мөнгөн шагнал олгосон.	1	200.0	1	200.0							
7	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч Хярааны хонхор ХХК-д санхүүжилтийг илүү олгосон.	1	513.7	1	513.7							
8	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	Сумын ЗДНХ-ийг зориулалт бусаар зарцуулсан.	1	5,000.0					1	5,000.0			
9	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ЗДНХ-ийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан.	1	550.0	8				1	550.0			
10	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг комиссын актаар хүлээж аваагүй байхад үлдэгдэл санхүүжилтийг олгосон.	1	3,657.5					1	3,657.5			
11	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь албан хаагчдад илүү цагаар ажилласан хөлсийг "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-аар баталгаажуулаагүй, тухай бүр бус жилийн эцэст цалингийн хэмнэлтээс олгосон.	1	13,243.3					1	13,243.3			
12	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	ЭМТ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас эмийн өр төлбөр үүсгэсэн.	1	1,362.0					1	1,362.0			
13	ТТЗ	СЭА-2022/01-НА-СТА-ТТЗ	ИТХ, Соёлын төв нь анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	500.0					1	500.0			

